

шашин, үндэстэн ястны ихээхэн зөрчилтэй, хил хязгаарын маргаан зөрчил нь шийдвэрлэгдэж дуусаагүй... зэрэг нь энэ гүрний ирээдүй геополитикийн үүднээс нэн сүүдэртэй байгаа явдал юм. Гэтэл ОХУ-д үзүүлэх АНУ-ын стратегийн дарамт шахалт хүчтэй болж, БНХАУ-ын үндэсний нийт чадавхи хурдан өсч байгаа нь манай Монголын санааг зовоохгүй байж чадахгүй. Бид бамбай улсынхаа статусыг улам бэхжүүлэх, хоёр хөршийн нөлөөний хэмжээг аль болох тэнцвэртэй байлгах талаар төрийн геополитикийн цогц бодлого боловсруулан мөрдөх хэрэгтэй гэж санагдана.

Харин ОХУ-ын ерөнхийлөгч В.В. Путин Монголд айлчилж, Азид явуулах Оросын бодлогод Монгол ач холбогдолтойг тэмдэглэн, хоёр орны харилцаанд ач холбогдол өгч буйгаа нотолсон нь манай улсын геополитикийн тэнцвэрт байдалд зохих хэмжээгээр нөлөөлөхүйц үйл явдал болсон билээ.

Тайлбар зүүлт:

1. Ю.В. Тихонравов. Геополитика М. 2000. Стр.235
2. SFS/NUM, "Mongolia's Geopolitics: Past, Present and Future", UB, 1995
3. Баабар. ХХ зууны Монгол: нүүдэл суудал, гарз олз... 1996, х.152
4. Ишлэлийг Г.Төмөрчулуун "Процесс принятия внешнеполитические решений в малых государствах (на примере Монголии)", "М. 1999, номоос авав, с.75-76
5. В.И. Ленин. Полн. собр. соч.-Т. 44, с. 232
6. Ю.Гарушяниц. Борьба за признание независимости Монголии. ПДВ, №2, 1997, с.113
7. См. Советско-Китайские отношения. 1917-1957. Сборник документов, М., 1959, с. 65
8. "Мировая экономика и международные отношения", №9, 1994, с. 17
9. SFS/NUM "Mongolia's Geopolitics: Past, Present and Future" Report of an International Conference, Ulaanbaatar, 1995, "Старый-Хартланд" и новый мир: альтернатива-море-или межцивилизованный буфер"
10. А.Дугин. "Основы геополитики: геополитическое будущее России" М. 1997, стр. 337-338
11. Мөн тэнд. х. 343
12. А.Дугин... х. 363. Монгол-Төвдийн холбооны тухай үзэл санааг Н.А.Нартов ч дэмжиж байна. См. Н.А.
13. А.В.Митрофанов. Шаги новой геополитики, "Русский вестник", М., 1997, с. 211

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛ БА ЧИНГИС ХААНЫ "ИХ ЗАСАГ" ЦААЗ

МУИС, ОУХС-ийн багш,
доктор (Ph.D) Д.Уламбаяр

Монгол Улс феодалын байгууллын дунд үед өрнө, дорнын хэрэгт нөлөө бүхий гүрэн болж байсан учир гадна, дотнын аянчин, жуулчид хийгээд түүхч эрдэмт мэргэдийн бичиг тэмдэглэл, шашдир түүхэнд гүн тэмдэглэгдэн үлджээ. Сайхь бүтээлүүд нь бидэнд эртний монголчуудын хууль цаазны сэтгэлгээтэй холбоотой чамлахааргүй сурвалж мэдээг лав өгүүлэх ажээ. Ер нь XIII-XIV зууны үеийн монголчуудын нийгэм, улс төрийн давхаргын түүхийг судлахад тэр цагийн хууль цаазны дурсгалууд үлэмж ач холбогдолтой. Үүнд, юуны өмнө "Их Яса" буюу "Их засаг" хэмээх Чингис хааны хуультай холбоотой мэдээ, материалуудыг хэлж болно.

Түүхч ал-Маркизи-ад-Дин, Матаки, Г.А.Масакин, Ибн-Батута, В.Вардана, Мирхованда, Григор Акнерц, ата-Малик Жувеин, Рашид-ад-Дин, нэрт жуулчин Плато Карпини, Вильгельм Рубрук, Марко Поло нар "Их засаг" хуулийн нэлээд зүйл ангийг өөрсдийн бүтээл, аян замын тэмдэглэлдээ тусгасны гадна мөн алтан ургийнхны нууц түүх "Монголын нууц товчоон"-д энэ тухай өгүүлдэг.

"Их засаг" хуулийг судлах талаар нэрт эрдэмтэд (Г.В.Вернадский, В.В.Бартольд, Б.Я.Владиморов, П.С.Попов, П.Березин болон бусад) ихэд анхаарч, бүтээлүүддээ онцлон тэмдэглэж байжээ. Харин проф. В.А.Рязановский энэ ажилд тусгайлан зүтгэл гаргаж, олон сурвалж материалуудыг шүүрдсэний үндсэн дээр "Монголын эрх зүй, хэв ёс" (1931), "Чингис хааны Их Яса" (1933) хэмээх томоохон хоёр номыг Харбин хотноо хэвлүүлсэн нь энэ чиглэлээр гарсан бүтээлүүдийн оргил болсон байна. Академич Ш.Нацагдорж, Ш.Бира, сурвалжлагч гишүүн Х.Пэрлээ нар ч бүтээлүүддээ асуудлыг хөндсөн нь бий.

¹ Хориг, цааз гэсэн утгатай үг ажээ.

Чингис хаан XIII зууны эхээр олон монгол аймгийг нэгтгэж улс гэрийг байгуулахад нийт монголын хэмжээнд мөрдөгдөж байх бичигдэл хууль "Их засаг"-ийг тогтоожээ. Гэхдээ энэхүү "Их засаг" хэмээх нь гэнэт гарч ирээгүй гэдэг нь илэрхий. Учир нь эртнээс монголчууд өөрсдийн амьдралд ардын хэв ёсыг баримталж байсан бөгөөд тиймээс ч тэр нь цаашдын хөгжлийн явцад улам баяжин олон талтай болж улмаар хууль цаазыг шинжийг олж эцэстээ бичмэл хууль үүсэн гарахын эх үндэс болжээ. Нөгөөтэйгүүр Жагар, Түвд, Хатан зэрэг суурьшмал газар орны хууль, цаазын нөлөө ч улбаалсан талтай юм. Ийнхүү Монголд анхны бичигдэл хууль гарч, энэ нь түүхэнд "Их засаг" (Яса) хэмээн алдаршжээ. Академич Б.Я.Владиморцов тэмдэглэхдээ: "Чингис хааны үед монголчуудын дунд мэдээжийн илэрхий болсон "Чингис хааны тогтоол" засаг нь монголын хэв заншил, ардын хэв ёсыг хууль цаазыг шинжтэй болгосон зүйл байсан бололтой" гэжээ.

XIII зууны үеийн монголчуудын нийгэм-улс төрийн байгууламжийг өгүүлэх "Их засаг" хууль бидний үед бүрэн уламжлагдаж ирээгүй бололтой, гэвч энэхүү хуулийн тухай түүхийн олон сурвалж бичиг бий юм. "Чандмань эрх" сударт тэмдэглэснээс үзвэл: Их эзэн Чингис хаан өөрийн улсын бичиг номын болон цэцэн ухаант арван найман их эрдэмт мэргэдийг шавь нарынх нь хамт урин авчирч өөрийн хууль тогтоомжийг эмхэтгэхийг тэдэнд зарлиг болгожээ. Уг хууль нь (хуйлсан бичиг) бүх дээдэс, тэдний харьяат нарыг юуны өмнө их эзэн Чингис хаан өөрийнх нь үзэл бодлыг бүх талаар тусгасан энэхүү хууль дүрмийг эмхэтгэх тухай зарлигийг ёсоор болгосонд эрдэмт мэргэдийг ихэд магтан дээдэлж, цол хэргэмээр шагнасан байна. Мөн Жувейнийн түүхэнд өгүүлсэн нь "Чингис хаан өөрийн бодсон ёсоор хэрэг бүрт хууль цааз, юм нь "Чингис хаан дүрэм, журам тогтоохын хамтад эдгээр засаг ба зарлиг дүрмийг хуйлмал цаасан дээр бичиж, тэмдэглэхийг зарлиг болгожээ. Энэхүү хуйлмал бичгийг "Засгийн их дэвтэр" хэмээн нэрлэж Их хааны ойрын ураг төрлийнхний санд хадгалдаг байв. Хаан их ор суух, их цэрэг хөдөлгөх, хааны ураг төрлийнхөн хуралдаж, засаг, төрийн хэрэг зөвлөн хэлэлцэх бүрд тэд энэхүү хуйлмал бичгийг эл гаргаж түүний дагуу ажил, хэргээ шийтгэнэ" гэжээ.

Египетийн төрийн гадаад харилцаа эрхэлсэн түшмэл, түүхч

Ал-Маркизи-ад-Дин (1361-1442) бичсэнээс үзвэл: Чингис хаан Ван хааныг ялж дээд засгийг олоод улмаар зарим үндсэн хууль, дүрэм, зарим ял шийтгэлийг тогтоож, энэ бүгдийг ном болгон бичиж "Их засаг" (Ясаг) гэж нэрлэжээ. Уул номыг хянаж дууссаны дараа Чингис хаан эдгээр хууль, дүрмийг болгд бүхий самбар дээр уйгар үсгээр сийлж бичихийг зарлиг болгож түүнийгээ өөрийн улс, үндэсний эмхтгэл хууль болгосон байна. Энэ нь тэдэнд бүрнээ нийцсэн учраас Чингис хааныг залгамжлагчид түүний заалтыг нэг ч номанд зөрчиж байсангүй ажээ. Алдарт түүхч Рашид-ад-Дин өгүүлэхдээ: Их хуралдай болж, хаан ширээ өргөмжлөхөд сайн болоод бэх бат хууль дүрэм зарлиг болгосон нь чухам өгөөмөр хэрэг болж нийтээр талархал хийжээ гэсэн байдаг.

"Нууц товчоон" "Их засаг"-тай холбогдуулан нэгэн баримтыг сонирхуулж байна. Эсгий туургатан улс энх шударга болж, барс жил (1206) Онон мөрний эхэнд хуралдаж, өсөн хөгт цагаан тугаа мандуулаад Тэмүүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өргөхөд тэрээр улс төрийг байгуулалцсан урьдын гавьяат нөхөр Шихихутт соёрхол хайрлаж өгүүлэхдээ: "Мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохижуулж байхад ч үзэх нүд, сонсох чих болж яв" "Шихихутуг чиний тушаасан үгийг хэн ч өөрчилж үл болно" гэж зарлиг болгоод бас Шихихутугийг "Бүх улсын доторхи хулгайг цээрлүүлж худлыг мохоон, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж бай" гэж бүх улсын дээд заргагч болгожээ. Бас "Нийт улсын өнгийг хувааж заргыг шийтгэж, түүнийгээ хөх дэвтэрт бичиж дэвтэрлэгүн". Надагтай зөвлөж Шихихутугийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүр өөрчилгүгэй" гэж зарлиг болгожээ.

"Нууц түүх"-ийн энэ мэдээг үндэслэж академич Ш.Бира "Хөх дэвтэр" бол "Засаг" хуультай холбоотой байж болохоос гадна засаг хууль нь эртний монголчуудын эрхэмлэдэг хөх өнгийн дэвтэрт анх бичигдэн яваандаа "Их дэвтэр" гэж нэрлэгдэх болсон байж болох юм гэсэн байдаг.

"Нууц товчоон", Рашид-ад-Динь уламжилсныг үзвэл "Их засаг" хуулийг анхлан эмхтгэж боловсруулахад Шихихутуг гардан оролцсон, ерөөс тэрбээр монголын хууль цаазыг сэтгэлгээний анхны томоохон төлөөлөгчийн нэг байжээ. Сурвалж бичгүүдийн нийтлэг санаа бол "Их засаг" хэмээх хууль байсныг илэрхий

өгүүлэхийн дээр түүнийг 1206 онд Монголын нэгдсэн улсыг байгуулж Чингисийг их хаан өргөмжилсөн их хуралдайгаар анх эмхтгэн боловсруулсан ажээ.

Ер тэр цагийн монголын нийгэмд хууль цааз буй болгох явдал үнэхээр шаардагдаж байжээ. Ийм хууль тогтоон явуулах нь юуны өмнө их хаан ба улс төрд хэрэгтэй байсан нь тодорхой. Ерөөс төр улс буй болоход ноёрхогч анти өөрийн эрхийн үзлийг хуулиар бэхжүүлж эрхийн хэм хэмжээгээр зохицуулдаг.

Эзэнт гүрний ерөнхий хууль Чингис хааны "Их засаг" (Үсэ)-т хаан өргөмжлөх, улсын их хуралдай хийх, гадаад олон улс лугаа харилцах, цэрэг, захиргаа, эрүү, иргэний цаазын зэрэг олон зүйлийг хуульчлан тогтоосон байна.

"Их засаг" хууль бидний үед бүрэн гүйцэд уламжлан ирээгүй бололтой хэдий ч басхүү сурвалж материалын мэдээг үндэслэн "Их засаг" хуулийн ерөнхий шинж, агуулгыг бас ч тодорхойлж болох ажээ.

Гадаад олон улс лугаа харилцахтай холбоотой хууль, эрхийн заалтаас: Дундад зууны үед улс хоорондын харилцаанд аливаа асуудлыг шийдвэрлэх түгээмэл арга нь дайн байснаас "хэн хүчтэй-түүний л зөв" гэсэн хууль ёс, гадаад бодлогод зонхилж байсан билээ. Монгол гүрний гадаад бодлого, дипломат ажиллагаа ч чухамхүү энэ зарчмын дагуу явагдаж байжээ.

Улс гэр байгуулагдаж, тэр үеэс монголчууд дэлхийн түүхийн тавцанд бие даан гарч ирсэн нь Монгол ба хөрш орнуудын харилцааны шинж чанарыг хувиргасан төдийгүй нийт Төв Ази цаашлаад Өрнө, Дорнын олон улсын харилцаанд томоохон өөрчлөлт оруулсан байна. Энэ нь Монгол улс хүчирхэгжиж улмаар дэлхий нийтээр төвшитгөн тохинуулах бодлого явуулсантай юуны өмнө холбоотой байжээ. Плано Карпиний бичсэнээр бол Монголын нэгдсэн улсын гадаад бодлогын ерөнхий чиг шугамыг Чингис хааны "Их засаг" хуульд тусган заахдаа: Бид.. бүх газар орныг дагуулан захирах ёстой ба урьдаас захирагдаагүй нэг ч улс оронтой найрамдал тогтоох ёстой" гэжээ. "Хүчээр түрээ барих" шинжтэй энэ заалт монгол гүрний гадаад бодлогын хөтөлбөргүй үндэс болж хатуу мөрдөгдөж байжээ. Үүнийг тэр үеийн их хаадын дипломат албан бичгийн утга санаа ч илтгэдэг байна. Тухайлбал: Гүюг хаан Ромын папад илгээсэн бичигтээ: "Мөнх тэнгэрийн хүчин дор наран

ургах зүгээс наран шингэх хүртэл бүх газар орон бидний ивээлд орсон" одоо та нар иргэн чинь болж эд орго бүхнээ өгье хэмээн үг өгүүлбээс зохино... Энэ үеэс эхлэн бид та нарыг ивээлдээ орсон гэж үзсүгэй. Хэрэв та нар тэнгэрийн бичгийг үл даган, миний зарлигийг зөрчвөөс дайсан минь болно... юу болохыг галцхуу мөнх тэнгэр мэдүгэй" гэжээ. Мөнх хаан Францын хаанд илгээсэн бичигтээ: "Дээр зөвхөн галц мөнх тэнгэр, дор газар ганц эзэн Чингис хаан байдаг" гэдгийг эхэлж дурдаад, элч ирүүлж, Монгол улстай "зохилдох, дайлах" хоёроо мэдэгдэхийг шаардаж байжээ.

Хубилай хаан Японы хаанд илгээсэн бичигтээ: "Бага орон их гүрний иргэн улс байх" ёстой, эс зөвшөөрвөл дайн хийх болно гэж сурдүүлж байжээ. Эдгээр бичгүүд тогтсон дипломат хэллэгээр төгсөнө. Тухайлбал: "Монголын Их хаан бол ертөнц дахины Далай их хаан болох учрыг илтгэж бичгүүдийн төгсгөлд ямагт "Мөнх тэнгэрийн хүчит Далай хааны их суу залийн үнэн дор (Энхжаргалт) дараа нь (хааны нэр) тэгээд зарлиг үг минү" хэмээдэг байсан аж.

"Их засаг" хуульд Нэгдсэн их улсын гадаад бодлогын чиг шугамыг тодорхойлсны гадна мөн гадаад харилцаа, дипломат ёслолын тухай заасан байна. Үүнд: Гадаадтай харилцах дээд эрхийг хаан өөрөө барих, дипломат харилцааны хэргийг галцхуу хааны нэрийн өмнөөс гүйцэтгэх, дипломат баримт бичгийг бэлтгэн явуулах (уйгаржин монголоор буюу дөрвөлжин үсгээр зохион үйлдэж, уул орныхны хэлээр хавсралт хувь үйлдэж, эцэст нь хаан гарын үсгээ зурж, төрийн тамга дарах) дайн, найрамдлын асуудлыг том язгууртан, ноёдын их хуралдайгаар хэлэлцэж шийдвэрлэх, гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах, харь орны элч төлөөлөгчдийг хүлээн авч уулзах, элчин солилцох, элч нарын дипломат халдашгүй дархан эрхийг хүндэтгэх, төрийн дайллага хийх, дипломат "тэргээ" шийтгэн олгох зэрэг орж байжээ.

Захираганы эрхийн холбогдолтой заалтаас: Монгол язгууртан ноёдын эрх, үүрэг болон хааны хэмжээгүй эрхийг засаг хуулиар хуульчлан тогтоожээ. Хаан өөрөө бүхий л эрхийг барьж, түүний зөвшөөрөлгүйгээр хэн боловч газар нутаг ажил төрөл сонгон авч үл болохын гадна хаад, ноёд хамжлага ардаас хэрэгтэй бүхнээ гаргуулан авахыг хуульчлан тогтоожээ. Үүнд: Түмт, мянгат, зуутын ноёд жилийн эхэн, адал хоёрт хаанд бараалхаж, түүнээс юу

сургамжлахыг сайтар сонсож, хариад цэрэг иргэдээ захирах, хэн өөрийн аж байдлыг сайн зохиож чадал тэр харьяат улсаа захирах чадна. Аравтыг захирах чадсан хүнд мянгат, түмтийг захируулж болно. Өөрийн арваныхыг захирах чадлаагүй аливаа ноёныг тэмтэн болгож, арваныхыг дотроос хэн чадахыг сонгож ноён тавина. Түмт, мянгат, зуутын ноёд үүнтэй адил. Улсын дотор юу болсныг түргэн мэдэж байхаар байнгын өртөө байгуулна. Цэрэг, иргэд, ноёд хаанаас өөр хүнд учир мэдүүлж болохгүй. Эдгээр заалтуудын аль нэгийг нь ямар нэгэн хэмжээгээр зөрчвөл шууд цаазаар авна хэмээжээ.

Эрүүгийн эрхийн холбогдолтой заалтаас: Египетийн түүхч Макризи, Арманий түүхч А.Масакин, В.Вартаана нар уламжлахдаа: Засагт тушаахдаа: бие биеэ хүндэтгэх, хүний болон бэлэвсэн эмэгтэйтэй явалдахгүй байх, хулгай хийхгүй байх, худал хэлэхгүй байх, заль мэх гаргахгүй байх, урван тэрсэлэхгүй байх, гуйланч байдал гаргахгүй байх үүнийг зөрчвөл цаазаар авна гэжээ. Мөн Ибн-Батута бичихдээ: Хэрэв морь хулгайлбал торлуулж төлөх, төлөх хөрөнгөгүй бол морины хамт хүүхдээ өгөх, хэрэв хүүхэдгүй бол хонь гаргаж өгөх адил цаазаар авна гэжээ. Мирховандагийн (Михонда) тэмдэглэснээс үзвэл: Цэрэг болон анчид ан авлахад салан задгай байдал гаргах, ан авыг хоосруулбал модоор занчих, заримдаа цаазаар аваачиж байжээ. Түүний бичсэнээс үзвэл: Бас засаг хуульд цаазаар авах ялыг хэлтрүүлж болох үндэслэлийг ч заажээ. Жишээ нь, цаазаар авах ял шийтгэгдсэн лал шашинт хүн дэчин алтан зоос, хятад хүн нэг илжиг өгвөл хэлтэрч болдог байжээ.

Иргэний эрхийн холбогдолтой заалтаас: Эхнэр авахын тулд сүй тавина, мөн олон эхнэртэй байж болно. Тийм нөхцөлд анхны эхнэр ахална. Татвар эхнэрээс гарсан хүүхдийг хууль ёсонд тооцож, зохих эрх эдлүүлнэ. Садан төрлөө эцгийн журмаар зөвхөн. I, II үеийг тооцно. Эцэг нь хөвгүүддээ өмч хуваарилна. Ахмад хөвгүүн дүү нараасаа илүү хувь хүртэнэ. Отгон хөвгүүн эцгийн гал голомтыг өвлөнө. Эцэг нас барахад хөвгүүд нь эхнэрүүдийн хувь заяаг шийднэ. Вилыгелым Рубрук бичихдээ: хүндэтгэх шалтгаангүй бол иргэн хүн заавал ажил хийж, ямар нэг үүрэг гүйцэтгэх ба цэргийн алба хаах, албан татвар төлөх, өртөө хийх, ан хоморгонд оролцох ёстойг хуульчлан заасан гэжээ.

Цэрэг, захиргааны холбогдолтой заалтын мэдээ: "Нууц товчоон"-д тэмдэглэсэн нь: "...Чингис хаан цааз тогтоож зарласан нь: Дайсныг дарах цагт олзонд бүү саатгун. Дайсан нэгэнт дарагдал тэдний юм хэзээд бидний олз болох тул хуваалцаж амжина. Хэрэв бид ухрахад хүрвэл анх довтолсон байрандаа даруй эгж ирээгүй хүнийг алтгай" гэж засаг тогтоож зарлав" гэжээ. Мөн "Их засагт" цэргийг захирах ноён ба цэргүүд байлдаанд орохдоо тус бүрийн алдар цолыг тэмдэглэж байх, цэргийн ноёд, хүүхэд багачуудыг сүм харвах, морь унахад сургаж эрэлхэг зоригт баатрууд болгох, мянгат зуутын ноёд өөр, өөрийн цэргийг хэзээд журамтай бэлхэн байлгаж хэзээ ч зарлиг буулгахад шөнө ч гэсэн морио унаж сааталгүй явах, довтлон байлдахын урьд захирагч нар өөрсдийн биеэр цэрэг ба зэвсгийг нүдээр үзэж магадлан, цэргүүдийн зүү, утсыг хүртэл шалгаж, хэнд, юу дутагдсаныг нийлүүлж өгөх, эмэгтэйчүүд нь эрчүүдээ тулалдаанд ороход тэдний ажил үүргийг гүйцэтгэж байхыг тус тус хуульчлан заажээ.

Шашны холбогдолтой зүйлсээс: "Их засаг" хуулиар бөөгийн шашныг ивээн хамгаалж төрийн гол шашин болгожээ. Үүнтэй холбогдуулж дурдахад гал барс жил буюу 1206 онд Онон мөрний хөвөөнд болсон монгол ноёдын их хуралдайгаар Хонхотын Мэнлиг эцгийн гуравдугаар хөвгүүн Хөхчүд, Тэв тэнгэр цол өргөмжилж гүрний их зайран бөө болгосон билээ. "Засагт" сүм хийд ба шашны мөргөл үйлдэгчийг хүндэтгэн аливаа албан татвараас чөлөөлдөг байсан тухай В.Вартаана уламжилжээ. Мөн харь улсын шашин шүтлэгийг өөрийн оронд чөлөөтэй байлгах явдлыг хуулиар хамгаалсан байна. Энэ нь бас улс төрийн нарийн учир холбогдолтой байжээ.

"Их засаг" хуулийг хэрэв алтан үргийн дотроос анх удаа зөрчвөл үгээр ятга, хоёр удаа зөрчвөл уран үгээр ухуулах, гурван удаа зөрчвөл Балж хуржирын уулзур хэмээх алс газар цөл, хэрэв тэнд очоод засралыг эс олбол гав тушаалаар бэхэлж хорь гэж зааж байсан нь сонирхолтой юм.

Чингис хааны "Их засаг" хуулийн гол агуулгыг хураан өгүүлбэл феодал ангийн эрх ашгийг бэхжүүлэхэд шууд чиглэгдсэн байна. "Их засаг" харц ардыг нэг аравтаас нөгөө аравтад, нэг зуугаас нөгөө зуугтад дур зоргоор шилжихийг хатуу хориглож, зөрчсөн хүнд шууд

цаазаар авах, ял оноохыг заажээ. Энэ бол чухамдаа харц ардуудыг (хамжлага) тус тусын эзэн ноён, түүний нутаг бэлчээрт хадаж бэхэлсэн хэрэг мөн. К.Маркс бичихдээ: "Их засагт дээд язгууртны тухай дурдахдаа аливаа алба татвараас чөлөөлөх, өөрийн олсон олзыг бусадтай хуваахгүйгээр их хаанд тогтмол чөлөөтэйгөөр оруулж байх, есөн удаагийн цаазын ялаас хэлтрүүлэх эрх мэдлийг хаанд олгожээ. Аж төрөх цэрэг ёсны үр дүнд хагас иргэншсэн бүх ард түмэнд иймэрхүү хэлбэрийн феодалын эрх зүй үүсч буй болсон байна" гэж тэмдэглэсэн байдаг. Засаг хууль нь феодалын харилцааг хуулиар бататган бэхжүүлж, овгийн байгууллын үлдэгдэлд мэдэгдэм цохилт өгснөөр тэр үедээ дэвшилтэт зүйл болжээ. Чухам үүнд "засаг хуулийн" гол ач холбогдол оршино.

Чингис хаанаас хойш түүний залгамжлагчдын дунд "Их засаг" хууль эзэнт гүрний хэмжээнд мөрдөн дагах ёстой гол хууль цааз болж байжээ. Бат хаан Оросын сүм хийдэд олгож байсан зарлиг бичигтээ: Засаг хуульд захирагдаагүй этгээдийг шууд цаазаар авна гэж заасан байна. Ил хаад тухайлбал, Хулагу хаан "Засаг хууль" -ийг улс төр, хувийн амьдралдаа чанд мөрдөж байсан бөгөөд ерөөс энэ хууль нь монголын ноёрхолд байсан ойрхи болон дундад дорнодын орнуудад үлэмж нөлөөтэй байсан тухай олон эх сурвалжид тэмдэглэжээ.

Чингис хааны "Их засаг" хууль хожим Монголын ноёрхолд байсан ойрхи болон дундад азийн төрт улсууд, цаашлаад Европ дахинын дотоодын хууль цааз, ялангуяа олон улсын эрх зүйн үүсэл, хөгжилд чухал нөлөө үзүүлжээ.

Тэр үед "Их засаг" хуулиас гадна Чингис хааны хэлсэн үг, зарлиг, тушаалыг эмхтгэсэн "билэг" гэдэг сургаал байсан байна. Энэ тухай Рашид-ад-Дин өгүүлэхийн хамт түүнийг хууль цаазны тусгай дурсгал бичиг гэж үзсэн байна. Эцэст тэмдэглэхэд XIII-XIV зууны үед Монголд улс төрийн сэтгэлгээ хөгжиж байсныг хууль цаазны дурсгалт бичгийн нэг нэгдсэн улсын албан ёсны анхны бичигдмэл хууль "Их засаг" (Яса) гэрчилж байна.

Ашигласан ном зүй:

1. Бартольд В.В. "Образование империи Чингис хана" Соч. У.М., 1968
2. Бартольд В.В. "Туркестан в эпоху монгольского нашествия" Соч. I. М., 1963

АЛТАН АРГАМЖ

3. Ш.Бираа. Чингисийн "Их засаг" хуулийн талаарх суулийн үеийн судалгааны дүнгээс "ОУМЭХ-ны сэтгүүл" №2 (20), №1 (21) УБ., 1997-1998
4. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ., 1966
5. Владимирцов Б.Я. "Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм" Л., 1934
6. Владимирцов Б.Я. Чингис хан. Улан-Удэ., 1995
7. Ж.Вернадский. "Чингис хааны Их Яса (засаг)-ийн судалгаа" УБ., 1993
8. М.И.Гольман. Изучение истории Монголии на западе XIII середины XX вв М., 1988
9. Григорьев А.П. "Монгольская дипломатика XII-XV вв" М., 1978
10. Григорьев А.П. "Чингизидские жалованные грамоты" Л., 1979
11. "Древний межгосударственный отношения и дипломатия" М., 1988
12. Н.Жалан-аажав "Халх журам бол Монголын эртний хууль цаазны дурсгалт бичиг мөн" УБр., 1961
13. Жамирано Ц.Ж. "Монгольские летописи" XVII вв. М-Л., 1936
14. Ч.Жүндэр "Монголд феодализм бүрэлдэн тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ" УБ., 1988
15. Котвич В. "XIII зууны эхэн үед Монголчууд дэлхий нийтийн энх тайвны санааг сэдэж, үүсгэсэн болох нь" /орч. Ц.Шагдарсүрэн/. Хэл зохиолын судлал. IX боть. 20 дугаар дэвтэр. УБ., 1972
16. Лувсанданзан "Алтан товч" УБ., 1990
17. Марко Поло "Ориентийн элдэв сонин" УБ., 1987
18. К.Маркс. "Разоблачение дипломатической истории XVII вв". Вопросы истории. 1989 №1-4 Магх К. "Secret Diplomatic History of the Eighteenth Century" Лон, 1899
19. Монгол-Татаарууд Ази-Европт УБ., 1984
20. Монголын нууц товчоон УБ., 1957
21. А.Мостерт, Ф.В.Кливер "Ил хаан Аргун, Өлзийт нараас 1289, 1305 онд Гоо Филиппт илгээсэн захидлууд" УБ., 1998
22. Ш.Нацагдорж "Чингисийн цади" УБ., 1991
23. Г.Нямдоо "Олон улсын хууль зүйн зарим асуудал" УБ., 1973
24. Плато Карпини "Монголчуудын түүх", Вильгельм де Рубрук "Дорно этгээдэд зорчсон минь" УБ., 1988
25. Рашид-ад-Дин "Судрын чуулган" 1-р боть. УБ., 1994
26. Рязановский В.А. "Великая Яса Чингис Хана", Харбин., 1933
27. Рязановский В.А. "Монгольская право" преимущественное и обычное (исторический очерк). Харбин. 1931
28. Товуу "Уйгаржин монгол үсгийн дурсгалт бичгүүд" Хөх хот., 1984